



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасч, бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хэнтий аймгийн Засаг даргын 2020 оны А/572, Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2020 оны А/127 дугаар захирамжаар Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын хөрөнгөд бүртгэлтэй, 450,000,000.00 (дөрвөн зуун тавин сая) төгрөгийн балансын үнэ бүхий газар эзэмших эрхийг дуусгавар болгосон тул хавсралтад заасан биет бус хөрөнгө (газар эзэмших эрх)-ийг данснаас хасч Орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын дарга Ж.Эрдэнэбат, Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Батсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201027

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын
2021 оны 01-дүгээр сарын 26-өдрийн
24-дугаар тогтоолын хавсралт



Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын данснаас хасч

Хэнтий аймгийн Орон нутгийн өмчид бүртгэх хөрөнгө

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)
1	Биет бус хөрөнгө, газар эзэмших эрх (Хэнтий аймаг Мөрөн сум 3-р баг)	2020	м2	300000	450,000,000.00
	Нийт дүн				450,000,000.00 (дөрвөн зуун тавин сая)